

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1.Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ГОРХИ-ТЭРЭЛЖИЙН
БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА Б.ХАШМАРГАД ТАНАА

2020.02.18 № 06/517
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Б.Хашмаргад Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 07-ноос 2020 оны 02 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Мэжик консалтинг аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Мөнхбаяр, аудитын менежер Г.Мөнхбаяр, аудитор Ч.Алтангэрэл, аудиторов туслах Б.Данзандорж нар хариуцаж хэрэгжүүлэв.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 20/31 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Байгалийн өвөрмөц тогтоц, экосистемийн онцлог төрх, байгалийн үзэгдэл, үйл явц болон нийслэл хотын ундны цэвэр усны нөөцийг хамгаалах, бүх нийтийн экологийн мэдлэгийг дээшлүүлж, байгалийн баялгийг зүй зохистой, тогтвортой ашиглах, аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагааг зохицуулахад оршино”.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны гол үйл ажиллагаа нь Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Нагалхааны байгалийн нөөц газрын хилийн зааг болон хил доторхи газар нутгийн байгалийн унаган төрхийг хадгалан хамгаалах, шинжлэн судлах, зүй зохистой ашиглахтай холбогдсон арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 271 дүгээр тогтоол;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд орсон өөрчлөлтүүдийг тус тус дагаж мөрдөж ажилласан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн Acolous 4.0 программ хангамж ашигладаг байна.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 6 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 443,631.6 мянган төгрөгөөс тооцон 4,436.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 185,313.5 мянган төгрөгөөр буюу 16 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	434.5	434.5
Урьдчилгаа	30,000.0	54,900.0	24,900.0
Бараа материал	59,569.9	202,274.4	142,704.5
Үндсэн хөрөнгө	1,068,785.7	1,086,060.2	17,274.5
Нийт хөрөнгө	1,158,355.6	1,343,669.1	185,313.5
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,158,355.7	1,343,669.2	185,313.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,158,355.7	1,343,669.2	185,313.5

Авлага дансны үлдэгдэлд 2019 онд үүссэн 434.5 мянган төгрөгийн авлага байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл өссөн нь биеийн тамирын талбай тохижуулах, авто зогсоол, био 00 хийх ажлын урьдчилгаанд 24,900.0 мянган төгрөгийн зардал гарснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрыг аялал жуулчлалын жишиг зорин очих газар болгон хөгжүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/541 тоот тушаалаар санхүүжүүлсэн хөрөнгөөр 112,729.0 мянган төгрөгийн материал авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 617 дугаар тогтоолоор “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслөөс үнэ төлбөргүй хүлээн авсан 99,275.0 мянган төгрөгийн барилга байгууламж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “Хөрөнгө хуваарилах тухай” А/82 тоот тушаалаар “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслөөс үнэ төлбөргүй хүлээн авсан 25,999.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрыг аялал жуулчлалын жишиг зорин очих газар болгон хөгжүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/541 тоот тушаалаар

санхүүжүүлсэн хөрөнгөөр авсан 15,000.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, 23,800.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, нийт 164,074.0 мянган төгрөгийн хөрөнгө орлого авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 389 тоот “Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” тогтоолоор 50,308.2 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,343,669.2 мянган төгрөг болж 185,313.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь тайлант онд 70,500.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 76,800.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 8.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого буюу нэвтрэх хураамж, нөхөн сэргээлтийн орлого нь 6,300.1 мянган төгрөгөөр давсан нь Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газраар аялах жуулчдын тооноос шалтгаалсан байна. 2019 онд гадаадын 17.8 мянган аялагч, дотоодын 75.0 мянган аялагч, нийт 92.8 мянган аялагч нэвтрэн өнгөрсөн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 255,665.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 255,665.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 185,165.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 70,500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн орлогыг задалж үзвэл улсын төсвөөс 185,165.8 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 76,800.2 мянга, нэмэлт санхүүжилтээр 219,625.6 мянган, нийт 481,591.6 мянган төгрөгийн орлоготой, 473,248.7 мянган төгрөгийн зарцуулалттай байна. Үлдэгдэл 8,342.9 мянган төгрөгийг төв төрийн санд татан төвлөрүүлсэн байна.

Урсгал зардлын төсөв 255,665.8 мянган төгрөг, гүйцэтгэлээр 254,151.8 мянган төгрөгийн зарцуулалт гарч, батлагдсан төсвийг 1,513.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна. Уг дутуу зарцуулсан дүнгийн 95.1 хувийг 1,462.2 мянган төгрөгийн бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал эзэлж байна.

Нэмэлт төсөв: Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрыг аялал жуулчлалын жишиг зорин очих газар болгон хөгжүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 160,000.0 мянга, “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслөөс 14,032.3 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоор 45,593.3 мянган төгрөг, нийт 219,625.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 212,696.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 590.0 мянга, хангамж, бараа материалын зардалд 873.4 мянга, нормын хувцас зөөлөн эдлэлд 7,068.0 мянга, багаж техник хэрэгсэлд 5,603.0 мянга, албан томилолтод 7,888.8 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 177,230.1 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 6,400.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, үлдэгдэл 528.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 6 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 7 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,461.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,461.6 мянган төгрөгийн алдааг залруулж, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

54,900.0 мянган төгрөгийн урьдчилж гарсан зардал, 434.5 мянган төгрөгийн авлагыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 144 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхдээ бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийг буруу тайлагнасан, төсвийн гүйцэтгэлийн хувийг нарийвчлан гаргаагүй байна.

1.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах, үргүй зардал гарах, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ бүртгэсэн байх

1.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалыг дагаж мөрдөх, төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж байх,

1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Гаргасан алдаа дутагдлыг хүлээн зөвшөөрч, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаар болсон.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	89,569,922.21	257,608,973.87
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
31115	Нэмэлт санхүүжилтийн харилцах	-	-
33	АВЛАГА	-	434,539.00
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	-	434,539.00
34	УРЬДЧИЛГАА	30,000,000.00	54,900,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	30,000,000.00	54,900,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	59,569,922.21	202,274,434.87
354	Хангамжийн материал	59,569,922.21	202,274,434.87
35410	Бичиг хэргийн материал	1,699,484.50	1,376,808.66
35420	Аж ахуйн материал	1,249,040.00	225,460.00
35430	Сэлбэг хэрэгсэл		2,001,600.00
35440	Түлш шатах тослох материал	3,791,300.00	2,170,409.00
35450	Барилгын материал	1,080,000.00	1,080,000.00
35460	Хүнсний материал	2,770,040.56	5,789,084.00
35470	Бусад хангамжийн материал	48,980,057.15	189,631,073.21
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,068,785,746.87	1,086,060,176.39
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,068,785,746.87	1,086,060,176.39
392	Биет хөрөнгө	1,026,015,746.87	1,044,060,176.39
39201	Барилга, байгууламж, орон сууц	768,974,802.82	831,195,054.48
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	- 37,101,268.37
39203	Авто тээврийн хэрэгсэл	266,603,138.97	262,523,138.97
39204	Хуримтлагдсан элэгдэл	- 133,058,464.86	- 162,010,787.45
39205	Машин тоног төхөөрөмж	102,097,454.88	151,896,477.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	- 35,176,613.28	- 55,698,298.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,687,232.18	16,687,232.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	- 4,673,794.84	- 7,215,017.92
39214	Бусад үндсэн хөрөнгө	63,098,186.72	68,924,736.34
39215	Хуримтлагдсан элэгдэл	- 18,536,195.72	- 25,141,090.58
393	Биет бус хөрөнгө	42,770,000.00	42,000,000.00
39301	Программ хангамж	770,000.00	770,000.00
39302	Хасагдуулга	-	- 770,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө /газар/	42,000,000.00	42,000,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,158,355,669.08	1,343,669,150.26
	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2019 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
413	Өглөг	-	-
4131	Ажиллагсадтай холбогдсон өглөг	-	-
	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,158,355,669.08	1,343,669,150.26
5.1	Засгийн газрын хувь оролцоо	1,158,355,669.08	1,343,669,150.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	159,944,500.00	159,944,500.00
51101	Өмч: - төрийн	159,944,500.00	159,944,500.00
512	Хуримтлагдсан үр дүн	954,579,723.88	1,139,893,205.06
51210	Өмнөх үеийн үр дүн	338,194,812.53	954,579,723.88
51220	Тайлант үеийн үр дүн	616,384,911.35	185,313,481.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	43,831,445.20	43,831,445.20
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,158,355,669.08	1,343,669,150.26

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,044,351,062.39	628,945,064.45
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	720,773,262.39	223,595,895.32
	Нийтлэг татварын бус орлого	720,773,262.39	223,595,895.32
	Төсөв байгууллагын өөрийн орлого	720,773,262.39	223,595,895.32
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	59,858,300.00	76,800,164.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,123,281.46	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	645,791,680.93	146,795,731.32
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	323,577,800.00	405,349,169.13
	Улсын төвлөрсөн төсвөөс	172,956,200.00	185,165,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	172,956,200.00	185,165,800.00
	Нэмэлт санхүүжилтийн орлого	150,621,600.00	219,625,602.13
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	46,425,000.00	14,032,302.13
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,000,000.00	160,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	87,196,600.00	45,593,300.00
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	577,767.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	577,767.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	410,628,451.00	417,038,725.32
	УРСГАЛ ЗАРДАЛ	410,628,451.00	417,038,725.32
	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	406,146,869.54	401,738,081.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	150,814,170.57	190,569,938.00
210101	Цалин	150,814,170.57	190,569,938.00
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,896,796.93	23,937,872.95
210201	Тэтгэврийн даатгал	10,860,037.01	16,277,754.15
210202	Тэтгэмжийн даатгал	1,504,315.48	1,915,027.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,222,958.83	1,532,023.72
210204	Ажилгүйдлийн даатгал	300,854.75	383,007.38
210205	Эрүүл мэндийн даатгал	3,008,630.86	3,830,059.80
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,443,600.00	24,984,491.00
210301	Гэрэл, цахилгаан	11,183,100.00	22,233,514.00
210302	Түлш, халаалт	13,815,000.00	1,715,477.00
210303	Цэвэр, бохир ус	445,500.00	1,035,500.00
	Хангамж, бараа материалын зардал	43,304,391.03	19,714,722.84
210401	Бичиг хэрэг	9,849,914.94	2,181,007.84
210402	Тээвэр, шатахуун	17,582,200.00	13,914,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,738,800.00	2,411,431.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,790,158.00	720,737.00

**Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2019 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит**

210407	Аж ахуйн материал худалдан авсан зардал	-	487,047.00
210408	Бараа материал акталсны зардал	10,343,318.09	-
	Нормативт зардал	2,441,998.30	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,441,998.30	-
	Эд хогшил, урсгал засварын зардал	4,724,368.75	755,600.00
210601	Багаж хэрэгсэл	1,372,500.00	-
210604	Урсгал засвар	3,351,868.75	755,600.00
	Томилолт, зочны зардал	681,600.00	9,928,829.00
210702	Дотоод албан томилолт	681,600.00	9,928,829.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,204,832.50	5,558,943.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	83,835,332.50	4,189,443.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,000,000.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	320,000.00	320,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	49,500.00	49,500.00
	Бараа үйлчилгээний бусад зардал	75,635,111.46	126,287,684.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	3,140,956.56
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	3,113,500.00	2,940,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	72,521,611.46	120,206,727.79
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,481,581.46	15,300,644.18
	Бусад урсгал шилжүүлэг	-	6,957,767.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	557,767.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,400,000.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,481,581.46	8,342,877.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,481,581.46	8,342,877.18
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	633,722,611.39	211,906,339.13
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	17,337,700.04	26,592,857.95
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	- 26,592,857.95
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		26,592,857.95
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	17,337,700.04	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	616,384,911.35	185,313,481.18

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	398,559,381.46	482,149,333.13
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	74,981,581.46	76,800,164.00
	Нийтлэг татварын бус орлого	74,981,581.46	76,800,164.00
	Төсөв байгууллагын өөрийн орлого	74,981,581.46	76,800,164.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжилт	59,858,300.00	76,800,164.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжилт	15,123,281.46	-
	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	323,577,800.00	405,349,169.13
	Улсын төвлөрсөн төсвөөс	172,956,200.00	185,165,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	172,956,200.00	185,165,800.00
	Нэмэлт санхүүжилтийн орлого	150,621,600.00	219,625,602.13
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	46,425,000.00	14,032,302.13
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	17,000,000.00	160,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	87,196,600.00	45,593,300.00
	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	557,767.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	557,767.00
	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	398,559,381.46	482,149,333.13
	УРСГАЛ ЗАРДАЛ	398,559,381.46	482,149,333.13
	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	394,077,800.00	466,848,688.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	143,920,200.00	175,767,382.85
210101	Үндсэн цалин	110,906,100.00	135,653,882.85
210102	Нэмэгдэл	23,584,500.00	30,683,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,429,600.00	9,429,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,270,300.00	22,756,576.10
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	11,825,300.00	16,175,776.10
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,361,200.00	1,645,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын шимтгэл	1,089,000.00	1,316,200.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	272,200.00	329,000.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	2,722,600.00	3,290,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,943,600.00	25,083,600.00
210301	Гэрэл, цахилгааны зардал	11,183,100.00	16,957,600.00
210302	Түлш, халаалтын зардал	13,315,000.00	7,090,500.00
210303	Цэвэр, бохир усны зардал	445,500.00	1,035,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,872,700.00	7,240,867.00
210401	Бичиг хэрэг	6,931,300.00	1,030,767.00
210402	Тээвэр, шатахуун	15,093,500.00	3,712,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,738,800.00	2,388,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,109,100.00	109,100.00
2105	Нормативт зардал	346,500.00	7,414,500.00

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2019 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	346,500.00	7,414,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,473,100.00	8,326,100.00
210601	Багаж техник хэрэгсэл	2,898,100.00	5,751,100.00
210604	Урсгал засвар	3,575,000.00	2,575,000.00
2107	Томилолт, зочны зардал	681,600.00	9,928,829.00
210702	Дотоод албан томилолт	681,600.00	9,928,829.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	167,456,300.00	207,217,334.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	166,086,800.00	205,847,834.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,000,000.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	320,000.00	320,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	49,500.00	49,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,113,500.00	3,113,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,113,500.00	3,113,500.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,481,581.46	15,300,644.18
	Бусад урсгал шилжүүлэг	-	6,957,767.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	557,767.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,400,000.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,481,581.46	8,342,877.18
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,481,581.46	8,342,877.18
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	338,194,812.53	338,194,812.53
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	338,194,812.53	338,194,812.53
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	43,831,445.20	-	43,831,445.20
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	159,944,500.00	-	-	159,944,500.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	616,384,911.35	616,384,911.35
8	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	159,944,500.00	43,831,445.20	954,579,723.88	1,158,355,669.08
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	159,944,500.00	43,831,445.20	954,579,723.88	1,158,355,669.08
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
12	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	-	-	185,313,481.18	185,313,481.18
16	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	159,944,500.00	43,831,445.20	1,139,893,205.06	1,343,669,150.26

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	255,665,800.00	254,151,889.75	1,513,910.25	99.4
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	255,665,800.00	254,151,889.75	1,513,910.25	99.4
210	Бараа, үйлчилгээний зардал	255,665,800.00	254,151,889.75	1,513,910.25	99.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	164,521,800.00	164,515,359.75	6,440.25	100.0
210101	Үндсэн цалин	124,408,300.00	124,401,859.75	6,440.25	99.9
210102	Нэмэгдэл	30,683,900.00	30,683,900.00	-	100.0
210103	Унаа болон бусад нөхөн олговор	9,429,600.00	9,429,600.00	-	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,565,100.00	20,565,100.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	13,984,300.00	13,984,300.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,645,200.00	1,645,200.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,316,200.00	1,316,200.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	329,000.00	329,000.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,290,400.00	3,290,400.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,493,600.00	24,493,600.00	-	100.0
210301	Гэрэл цахилгаан	16,957,600.00	16,957,600.00	-	100.0
210302	Түлш, халаалт	7,090,500.00	7,090,500.00	-	100.0
210303	Цэвэр, Бохир ус	445,500.00	445,500.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	6,367,500.00	6,367,467.00	33.00	100.0
210401	Бичиг хэрэг	1,030,800.00	1,030,767.00	33.00	100.0
210402	Тээвэр (шатахуун)	2,838,800.00	2,838,800.00	-	100.0
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,388,800.00	2,388,800.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	109,100.00	109,100.00	-	100.0
2105	Нормативт зардал	346,500.00	346,500.00	-	100.0
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	346,500.00	346,500.00	-	100.0
2106	Эд хогшил худалдан авах	2,723,100.00	2,723,100.00	-	100.0
210601	Багаж, техник хэрэгсэл	148,100.00	148,100.00	-	100.0
210604	Урсгал засвар	2,575,000.00	2,575,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	2,085,200.00	2,040,000.00	45,200.00	97.8
210702	Дотоод албан томилолт	2,085,200.00	2,040,000.00	45,200.00	97.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	31,449,500.00	29,987,263.00	1,462,237.00	95.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,080,000.00	28,617,763.00	1,462,237.00	95.1
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	320,000.00	320,000.00	-	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	49,500.00	49,500.00	-	100.0
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	3,113,500.00	3,113,500.00	-	100.0

Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны 2019 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,113,500.00	3,113,500.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	255,665,800.00	254,151,889.75	1,513,910.25	99.4
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	185,165,800.00	177,351,725.75	7,814,074.25	95.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	185,165,800.00	177,351,725.75	7,814,074.25	95.8
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	70,500,000.00	76,800,164.00	-	108.9
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,500,000.00	76,800,164.00	-	108.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	18	18	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	13	13	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4	4	-	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		219,096,799.20
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		219,096,799.20
210	Бараа, үйлчилгээний зардал		212,696,799.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		11,252,023.10
210101	Үндсэн цалин		11,252,023.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		2,191,476.10
210201	Тэтгэврийн даатгал		2,191,476.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		590,000.00
210303	Цэвэр, бохир ус		590,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		873,400.00
210402	Тээвэр (шатахуун)		873,400.00
2105	Нормативт зардал		7,068,000.00
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл		7,068,000.00
2106	Эд хогшил худалдан авах		5,603,000.00
210601	Багаж, техник хэрэгсэл		5,603,000.00
2107	Томилолт, зочны зардал		7,888,829.00
210702	Дотоод албан томилолт		7,888,829.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		177,230,071.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		177,230,071.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		6,400,000.00
	Бусад урсгал шилжүүлэг		6,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		6,400,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		219,625,602.13
	Нэмэлт санхүүжилтийн орлого		219,625,602.13
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж		14,032,302.13
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		160,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		45,593,300.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020.02.14			САГ-2020/109/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Горхи-Тэрэлжийн БЦГ-ын хамгаалалтын захиргаа		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	1,461.60	Залруулга хийлгэж, зөвлөмж өгсөн	Дарга Ерөнхий нягтлан бодогч	Б.Хашмаргад Б.Гандолгор

[illegible]

[illegible]

[illegible]